# ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 10. Хэрлэн сум

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 1: “****Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” **гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах; | - | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан. | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна. | Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын талаарх сургалтыг 831 нэгжид хийж нийт 13391 иргэд, даатгуулагчдыг сургалт, уулзалтад хамруулж ажилласан байна. Албан хаагчдад хууль хэрэгжүүлэхээр гаргасан дүрэм, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | журам, зааврыг танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгч өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн дээд шатны байгууллагаас ирүүлсэн заавар, чиглэлийг төвийн болон сумдын байцаагч нарт тухай бүр танилцуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд хууль тогтоомж, ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар болон бусад хэлбэрээр иргэд даатгуулагчид шуурхай хүргэн ажилласан байна. 2025 онд Нийгмийн даатгалын газар нь “Хэнтийн Мэдээ сонин” агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулан Нийгмийн даатгалын хуулийг сурталчлах, нийгмийн даатгалын байгууллагын үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг иргэд даатгуулагчид түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан. Гэрээний хүрээнд 14 reel, content, 12 постерийг хийж олон нийтэд түгээсэн байна. Мөн НДЕГ болон Хэнтий аймгийн НДГ-ын пост, reel, мэдээ, мэдээллийг тухай бүр иргэд даатгуулагчид хүргэх, түгээх ажлыг нийт албан хаагчид хамтран шэйрлэж, түгээж хэвшсэн. Дээрх хийгдсэн ажлыг 2025 онд нийт 3011 удаа постолж, шэйрлэж, түгээн давтагдсан тоогоор 840 гаруй мянган хүний хандалт авсан байна. | |
| 1.2 | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах; | Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна. | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1288,7 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/302 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагааны зардал 1714.3 сая төгрөгөөр өөрчлөгдөн батлагдсан. Цалин | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөлсөнд 1330.8 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 172.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.9 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 12.9 сая төгрөгийг эдийн засгийн ангиллаар зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан. | |
| 1.3 | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах; | 10,5 сая | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, арга хэмжээний зардал шийдвэрлэгдээгүй тул сургалт зохион байгуулагдаагүй. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна. | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны санхүүжилт 10.5 сая төгрөгөөр батлагдсан. Нийгмийн даатгалын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу сонгон шалгаруулалтын зар мэдээг цахим хуудсанд байршуулсан. Зарын дагуу тус газарт ирүүлсэн байгууллагуудын танилцуулга, материалаас шаардлага хангасан “Эндээ хөгжил” ТББ сонгогдож 2025 оны 10 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалтаар гарсан зардалтай холбоотой холбогдох санхүүгийн анхан шатны баримтыг нягтлан, шалгасны үндсэнд 100% төлбөрийг шилжүүлсэн. | |
| 1.4 | Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | - | 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна. | Ажил олгогч, даатгуулагчдаас авах сэтгэл ханамжийн судалгааг хагас жил тутамд хийж | Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, | Ажил олгогч, иргэд, даатгуулагчдаас сэтгэл ханамжийн судалгааг “google form” программыг ашиглан Нийгмийн | 90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гүйцэтгэсэн байна. | судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна. | даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/184 дүгээр тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын үйлчилгээний талаарх сэтгэл ханамжийн судалгаа авах журам”-ын дагуу улирал бүр авч байна. 2025 онд нийт 335 даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авсан ба судалгаагаар 75 хувь нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээлэл, зөвлөгөө бүрэн авч чадсан, 31.6 хувь нь албан хаагчийн харилцаа хандлагын улмаас үйлчилгээ бүрэн авч чадаагүй гэж хариулсан байна. Алба хаагчдын харилцааны соёлыг 82.9 хувь нь хангалттай сайн гэж үнэлсэн бол 17.1 хувь нь мэдээлэл хангалттай өгөөгүй гэж дүгнэсэн байна. Дүгнэлтэд үндэслэн дараах | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажлуудыг зохион байгуулж ажилласан.<br>1. Байцаагч, албан хаагчдыг хувиар гарган угтах үйлчилгээнд ажиллуулж байна.<br>1. Ёс зүйн дэд хорооноос алба хаагчдад ёс зүйн тухай хууль, харилцаа хандлагын сургалт хийсэн. НДЕГазрын дэргэдэх ёс зүйн хорооноос зохион байгуулсан сургалтуудад байцаагч алба хаагчдыг хамруулсан.<br>2. Үйлчилгээний заалны эмх цэгц, цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулсан<br>3. Үйлчилгээний зааланд цахимаар өөртөө үйлчилгээ авах боломж бүрдүүлж дижитал мэдээллийн самбар, хурдан киоск төхөөрөмжийг ажиллуулж байна. | |

***Биелэлт – 390 / 4 97.5 %***

***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт***

***Зорилт 2:*** *“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт,чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах,*

<table>
<tr><td colspan="8">мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</td></tr>
<tr>
<td>2.1</td>
<td>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.</td>
<td></td>
<td>НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.</td>
<td>Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 58898,9 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн.</td>
<td>НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.</td>
<td>НДЕГазрын даргын 2023 оны А/183 дугаартай тушаалын дагуу төрийн сангийн төвлөрсөн орлогын дансны орлогыг тухай бүр нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд төвлөрүүлэн ажилласан. 2025.11.30-ны өдрийн байдлаар 94 удаагийн гүйлгээ хийж 74,688,98 сая төгрөгийн орлогыг төв санд төвлөрүүлсэн байна.</td>
<td>100%</td>
</tr>
<tr>
<td>2.2</td>
<td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.</td>
<td></td>
<td>Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.</td>
<td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.</td>
<td>а/ Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна.<br>б/ Төсвийн хуваарьт оруулах саналаа тухай бүр НДЕГ-т хүргүүлсэн байна.</td>
<td>а/ Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сан тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан.<br>Сангийн зарцуулалт / сая төг/
<table>
<tr><td>Сан</td><td>Төлөв лөгөө</td></tr>
<tr><td>Тэтгэвэр</td><td>122726,</td></tr>
<tr><td>Тэтгэмж</td><td>5932,9</td></tr>
<tr><td>ҮОМШӨ</td><td>5810,4</td></tr>
</table>
</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | в/ Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна. | Ажилгүй дэл \| 2901,9 \| 2985,6 \| 102,9<br>**нийт \| 137371,9 \| 137371,9 \| 100**<br>б/ Ажилгүйдлийн даатгалын сангийн санхүүжилт хүрэлцэхгүй байгаатай холбоотойгоор төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг НДЕГ-ын БХСГазарт 2025 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн 03/50 дугаартай албан тоот, 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр тус тус хүргүүлсэн.<br>в/ Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого НДЕГ-ын төв сан руу 74688.98 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас төв сан руу 40.0 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан. НДЕГ-аас санд 100845.8 сая төгрөгийн санхүүжилт, 21090.35 сая төгрөгийн улсын төсвийн санхүүжилт авсан. | |
| 2.3 | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд | Батлагдсан 1288,7 сая төгрөгийн төсвийг зардал | а/ Төрийн хэмнэлтийн тухай | а/ Төрийн хэмнэлтийн тухай хууль болон НДЕГ-ын даргын 2025 | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | ангиллын дагуу 1178,5 сая төгрөг зарцуулсан. | хуулийг хэрэгжүүлэх. б/ Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в/ Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | оны 11 дүгээр сарын 14-ний 01/3015 тоот албан бичгийн дагуу зардал тус бүрийг хэтрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан ажил үйлчилгээг явуулсан. 2025 онд шинээр бэлтгэсэн хөрөнгө НДЕГ-ын даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ний өдрийн А/309 тушаалаар тоног төхөөрөмж дансанд нийт 53.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлд авсан. НДЕГазрын даргын 2025 оны 9 дүгээр сарын 10-ний өдрийн А/239 дугаар тушаалаар 41 орон тоо батлагдсан. Үүнээс 37 ажилтан албан хаагч ажиллаж, хүүхдээ асрах чөлөөтэй 1, жирэмсний болон амаржсаны чөлөөтэй 1 байцаагч байна. б/ Байгууллагын үйл ажиллагааны зардалд 1714,3 сая төгрөгийг эдийн засгийн ангилал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулалтыг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан.<br>в/ Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТатварыг тухай бүр шилжүүлж өглөг, авлага үүсгэлгүй ажилласан болно. | |
| 2.4 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг үнэн | Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 02-ний өдрийн дотор НДЕГазарт Сикос системээр илгээж байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг байгууллагын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | мэдээллийн самбар болон шилэн дансанд байршуулан нийтэд мэдээлж мөн аймгийн статистикийн хэлтэс, нийгмийн бодлогын хэлтэст сар бүр хүргүүлэн ажиллаж байна.<br>Дараах мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн болно.<br>-Сарын мэдээ 12 удаа<br>-Нийгмийн даатгалын сангийн өглөг, авлагын мэдээ 12 удаа<br>-Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ 12 удаа<br>-Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан 2 удаа<br>-Байгууллагын санхүүгийн тайлан 2 удаа<br>-Э-тайлан 1 удаа тус тус НДЕГазраас ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь чанартай гаргаж цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан.<br>Санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын мэдээг сар бүр гаргаж 12 удаа Green EPR системээр илгээсэн. | |
| 2.5 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгийн мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээллэх;<br>-Хагас болон бүтэн жилийн | а/ НДЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийн 02/138 албан бичгийн дагуу үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах саналыг НДЕГазарт холбогдох бичиг баримтын хамт хүргүүлсэн. Үүнд: Тоног төхөөрөмж 2.3 сая төгрөг, тавилга эд хогшил 0.8 сая төгрөг, барилга 0.9 сая төгрөгийн хөрөнгө байна.<br>б/ ТӨ1-ТӨ11, ТӨХ маягтыг НДЕГ-ын Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газрын дотоод сүлжээнд 2025.04.01-ны дотор хугацаанд байршуулж хүргүүлсэн.<br>в/ НДГазрын даргын 2025 оны 06 дугаар сарын 26-ний өдрийн А/15 дугаар тушаалаар эд хөрөнгийн хагас жилийн тооллогыг 4 хүний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжү | бүрэлдэхүүнтэй зохион байгуулан ажилласан.<br>Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг НДГазрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/25 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй батлан тооллогын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>г/ Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллаж 2025 оны байдлаар 1 удаа “Үндсэн хөрөнгө актлах, данснаас хасах” саналаар хуралдсан байна.<br>д/ НДЕГ-ын 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 01/707 албан тоотын дагуу ТӨБЗГазрын burtgel.gov.mn цахим хуудсанд 2024 оны эд хөрөнгийн хөдөлгөөн, санхүүгийн жилийн эцсийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 07 нд хугацаанд оруулсан.<br>ТӨБЗГазар 2025 оны 04 сарын 14 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах6 | нд хүлээн авч баталгаажуулсан. е. ТӨБЗГазартай 2024 оны гэрээ дүгнэж 82 хувьтай дүгнүүлсэн, түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно. | |
| 2.6 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б/ Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, | а/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "ЗӨРЧИЛГҮЙ" дүгнэлт авах. б/ Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн | а/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул Аймгийн Аудитын газраас **өөрчлөлтгүй** дүгнэлт авсан болно.<br>б/ Аудитын газраас 1-ээс дээш жилийн насжилттай 131.9 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулах албан шаардлага тавигдсанаас 98.0 сая төгрөг буюу 74.30 хувийг барагдуулан ажилласан. Барагдаагүй үлдсэн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагад хариуцагч нас барсан, Улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа гарахгүй, эзэн холбогдогчтой болоогүй өв хүлээн аваагүй, Улсын бүртгэлийн хэлтэс нь 2015 онд шимтгэлийн өртэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байхад татан буулгасан хариуцагчгүй зэрэг авлагууд үлдсэн болно. Аудитаар 1 албан шаардлага, 1 акт тавигдсан бөгөөд 100 хувь барагдуулсан биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр Төрийн Аудитын газарт цахимаар болон цаасаар хүргүүлсэн байна. | |
| 2.7 | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан. | а/ Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б/ Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | а/ Манай газар нь энэ онд НДЕГазар ХААН, ХАС, Төрийн банктай байгуулсан хамтран ажиллах ерөнхий гэрээний дагуу хэрэгжилтийг ханган ажилласан. 2025 онд тэтгэвэр олголтын файлыг сарын ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө харилцагч банкуудад цахимаар хүргүүлэн файл хүлээлцсэн акт үйлдэж сар бүрийн 01-нд тэтгэврийг олгож хэвшээд байна. Банкуудад тэтгэвэр олгосон үйлчилгээний хөлсийг тарифаар | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бодож ХААН банканд 5.2 сая төгрөг, Төрийн банканд 2.6 сая төгрөг, Голомт банк 0.2 сая төгрөгийг шилжүүлсэн. 2025 онд банктай байгуулсан гэрээний дагуу Хаан банк 46.4 сая төгрөг, Төрийн банк 5.5 сая төгрөг, Хас банк 0.6 сая төгрөг, Голомт банк 1.5 сая төгрөгийн хүүг тооцож ажилласан. | |
| 2.8 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а/ Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б/ Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж | а/ Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>б/ 2024 оны эцсийн үйлчилгээ буюу нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг хуваарийн дагуу татуулж хөрвүүлэн, тохируулга үйлчилгээг бүрэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээллийн сан бүрдүүлсэн байна. | хийлгэж баталгаажуулсан. | |
| 2.9 | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | "Core" системээр нягтлан бодох бүртгэлийн ажил үйлчилгээг НДЕГ-аас ирсэн заавар, чиглэлийн дагуу тухай бүр хийж гүйцэтгэсэн.<br>Системд гарсан алдаа дутагдлыг шалган, нягталж хариуцсан дээд газарт мэдэгдэн засуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Программын хөгжүүлэлт сайжруулалттай 32 саналыг 3 удаа албан бичгээр хүргүүлсэн. | 100% |
| 2.10 | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а/ Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах.<br>б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн | а/ Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлангаар өглөг, авлага гараагүй бөгөөд харилцагч байгууллагуудтай өр авлагагүй гэсэн тооцоо нийлсэн актыг улирал бүр нийлж баталгаажуулан ажиллаж хэвшсэн.<br>б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна. | тайлангаар гарсан өглөг, авлагын үлдэгдлийг хариуцсан байцаагч, байгууллагатай тооцоо нийлэн улирал бүр баталгаажуулан ажиллаж байна. | |
| ***Зорилт 2.1:*** *“Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 2.1.1 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 851 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 400 малчин шинээр хамруулав. | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцож Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | 2025 онд сайн дурын даатгалд шинээр 672 даатгуулагч хамруулж сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөө 100 хувь биелүүлэн ажилласан. Нийт 3784 иргэн сайн дурын даатгал хамрагдсан байна. Үүнээс: 672 даатгуулагч шинээр хамрагдсан.<br>- Энгийн сайн дурын даатгуулагч хамрагдсан нийт 1086 бөгөөд шинээр 164 даатгуулагч<br>- Сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт 2285 бөгөөд шинээр 411 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | малчин хамрагдсан.<br>- 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 313 даатгуулагч хамрагдсанаас шинээр 58 даатгуулагч хамрагдсан.<br>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асраж байгаа эцэг, эхийг даатгалд нийт 102 даатгуулагч хамрагдсанаас шинээр 39 даатгуулагч хамрагдаад байна. | |
| 2.1.2 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах; | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь | 2024 онд 78 ажил олгогч, 283 хүнийг албан журмын даатгалд шинээр хамруулав. | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцож Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | 2025 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 95 ажил олгогчийг хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 445-аар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. | 100% |
| 2.1.3. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30 доошгүй хувиар бууруулах; | - | Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 23.13 хувиар буурсан байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас | а/ 2025 оны байдлаар урд оны авлага 1722.7 сая төгрөгөөс 1668.8 сая төгрөг буюу 97 хувийг барагдуулсан болно. Урсгал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | доошгүй буурсан байна. | авлага 1250,1 сая төгрөг байгаагаас төсвийн байгууллагын авлага 626,3 сая төгрөг байна. 8 ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 852,3 сая төгрөг, 412 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг хааж үл маргах журмаар 1162.3 сая төгрөгийн авлагыг барагдуулсан. Улирал бүр төсөвт байгууллагын авлагын судалгааг гарган дээд шатны байгууллага, төсвийн захирагч нарт, Төрийн сангийн хэлтэст хүргүүлж хамтран ажилласан. Улмаар төсөв нь байгаа хэдий ч гүйлгээ хийгээгүй тайлангаа удаа дараа хоцроосон 3 төсөвт байгууллагад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа хийж торгуулийн арга хэмжээ ногдуулсан. 5 нягтлан бодогчид хуулийн дагуу хариуцлага тооцсон. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | б/ Шүүхийн шийдвэртэй нэр бүхий 7 байгууллагатай холбоотой 104,6 сая төгрөгийн авлагаас 97,7 сая буюу 94 хувийг барагдуулсан. Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж амжилттай хамтран ажилласан. | |
| 2.1.4. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх; | | Шимтгэлийн өргүй гарсан байх. | Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 314.7 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өргүй байна. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах. | Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны оны эхний үлдэгдэл болох 1225,2 сая төгрөгийн шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байна. 2025 оны жилийн эцсээр өр авлагагүй байхад анхаарч Төрийн сан, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот газруудтай хамтран ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах; | - | Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна. | Нийгмийн даатгалын санд 61952,8 сая төгрөгийн орлого хуримтлуулав. | Нийгмийн даатгалын санд 74,7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ. | Нийгмийн даатгалын 2025 оны сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөө 74,448.48 сая төгрөг, гүйцэтгэл 74522,93 сая төгрөг буюу 100% биелүүлэн ажиллаад байна. | 100% |
| ***Биелэлт – 1475 /15 98.3 %*** | | | | | | | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | |
| ***Зорилт 3:*** *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих; | - | Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ. | Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу 48 мэдээллийг 2024 оны байдлаар 59.5 хувьтай байршуулсан. | Байгууллагын нээлттэй мэдээллийг ил тод болгож, иргэдийн мэдээлэл хайх, хүлээж авах эрхийг хангасан байна.Тайлан мэдээг хагас жилээр 07 дугаар сарын 09, оны эцэст 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус хүргүүлсэн байна. | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын цахим хуудсанд чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал, үзүүлж байгаа | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний талаарх мэдээлэл, бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын мэдээ, мэдээллүүдийг тухай бүр байршуулсан. Шил ажиллагааны shilen.gov.mn-д 2025 оны 1 дүгээр улирлын тайланг 2025.02.24-ний өдөр илгээж 94.3, 2 дугаар улирлын тайланг 2025.06.28 нд илгээж 97,5%, оны 3 дугаар улирлын тайланг 2025.09.29-ний өдөр илгээж 93.4%-ийн үнэлгээ авсан. | |
| 3.2. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих; | - | Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 167 мэдээллийг 2024 оны байдлаар 94.5 хувьтай хугацаандаа мэдээлэл байршуулсан. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүү болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж, иргэдийг үнэн, зөв мэдээллээр хангасан байна. Тайлан мэдээг хагас жилээр 07 дугаар сарын 09, оны эцэст 12 | Тус газар нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу Нийгмийн даатгалын газрын шилэн дансны хэрэгжилтэд улирал бүр хяналт тавин ажиллаж хийсэн ажлын тайланг Нийгмийн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус хүргүүлсэн байна. | даатгалын ерөнхий газрын ДАТГ-т хүргүүлэн ажилладаг. Мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай 03 тоот албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2025 оны тайлант хугацаанд шилэн дансны мэдээлэл байршуулалтад хийсэн хяналт шалгалтаар хугацаа хоцроож байршуулсан төлөвт байгаа 3 мэдээлэл байсан ба цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг болгосон. | |
| ***Зорилт 3.1:*** *"Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах, | - | Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, Шалгалтад хамрагдсан нийгмийн | Аж ахуйн нэгж, байгууллага болон нийгмийн даатгалын байгууллагын дотоод үйл ажиллагааг холбогдох журмын дагуу | Удирдамж гарган газрын даргаар батлуулах, хяналт шалгалт хийх | Нийгмийн даатгалын газар нь 2025 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөө, удирдамж гарган газрын даргаар батлуулж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн баргадуулалтын хувь. | хяналт шалгалт хийсэн. | | нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу гадаад болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Дотоодын хяналт шалгалтын ажлын хүрээнд: Тэтгэврийн тогтоолт, олголтоор 103 тэтгэвэр авагчид 105.6 сая төгрөгийг илүү, 31 тэтгэвэр авагчид 8.9 сая төгрөгийг дутуу олгосон зөрчил илэрсэн. Нийт 134 хүний 124.6 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 79 хүний 91.0 сая төгрөг буюу 73 хувийг барагдуулан ажилласан байна. Тэтгэмжийн тогтоолт, олголтоор 56 даатгуулагчид 66.4 сая төгрөгийг илүү, 18 даатгуулагчид 13.8 сая төгрөгийг дутуу тооцож олгосон зөрчил илэрсэн. Нийт 74 хүний 80.2 сая төгрөгийн төлбөр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөрчлөөс 65 хүний 74.6 сая төгрөг буюу 93 хувийг барагдуулан ажилласан байна. Сайн дурын даатгалын шимтгэл, ногдуулалттай холбоотой 59 даатгуулагчид залруулагийн акт үйлдэн, зөрчлийг арилган ажилласан. Улсын байцаагчийн актаар 29 байгууллагатай холбоотой 16.1 сая төгрөгийн шимтгэл, хугацаа хоцроосон хоногт 3.3 сая төгрөгийн алданги, нийт 19.4 сая төгрөгийн зөрчил илэрч, бүрэн барагдуулан ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаагүй 6 байгууллагатай холбоотой 2.0 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор шимтгэл ногдох орлогыг нуусан 1 байгууллагатай | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоотой 2.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, нийт 7 байгууллагыг 4.0 сая төгрөгөөр торгон, бүрэн барагдуулан ажилласан. Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу улиралд 1 суманд ажиллаж Дадал, Галшар, Норовлин, Бор-Өндөр сумдад дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар тэтгэврийн тогтоолт, олголттой холбоотой 2.8 сая төгрөгийг илүү, 3.5 сая төгрөгийг дутуу олгосон зөрчил, тэтгэмжийн тогтоолт олголттой холбоотой 42.1 сая төгрөгийг илүү, 24.1 сая төгрөгийг дутуу олгосон зөрчил илэрч төлбөрийг бүрэн барагдуулахаар байцаагч, ажилчдад үүрэг өгч, улсын байцаагчийн акт үйлдэн ажиллаа. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022-2024 оны ажилгүйдлийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, анхан шатны баримтад тулгуурлан шалгаж 60 даатгуулагчид 96.6 сая төгрөгийг илүү, 35 даатгуулагчид 26.6 сая төгрөгийг дутуу тооцож олгосон зөрчил илэрсэн. Нийт 123.2 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 95 сая төгрөг буюу 77 хувийг барагдуулсан. Тайлангаарх 13.7 сая төгрөгийн үлдэгдлийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд нөхөн тайлагнасан, цалин, даатгуулагчийн төрлийг өөрчилсөн, устгасан, даатгуулагчийн регистр зэрэг үндсэн мэдээллийг засварласан, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нэгтгэсэн байдалд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 54 байгууллагатай холбоотой 118 даатгуулагчийн 166.3 сая төгрөгийн цалин сангаас улсын байцаагчийн акт болон шүүхийн шийдвэрээр нөхөн тайлагнасан мөн даатгуулагчийн цалин, төрлийн залруулгыг 32 байгууллагат хийсэн бөгөөд нотлох баримт материал нь үндэслэлтэй, хуулийн дагуу шийдвэрлэгдсэн байна гэж үзэн тайланг хүргүүлсэн. Дотоодын хяналт шалгалтыг тогтмолжуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг таслан зогсоох ажлын хүрээнд 2024-2025 онд шинээр тогтоосон 290 тэтгэвэр авагчийн тэтгэврийн тогтоолт, олголтыг шалгасан. Шалгалтад 17 сумын тэтгэврийн хувийн хэрэг, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | материал хамрагдаж, 28 тэтгэвэр авагчтай холбоотой 9.9 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, 16 тэтгэвэр авагчтай холбоотой 7.2 сая төгрөгийг нөхөн олгохоор, нийт 17.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлэн ажилласан. Гадагшаа чиглэсэн хяналт шалгалтын ажлын хүрээнд: Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй 6 байгууллагатай уулзалт зохион байгуулж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаарх дутуу төлсөн 51.6 сая төгрөгийн шимтгэлээс хугацаа хоцроосон хоног тутамд 5.4 сая төгрөгийн алданги тооцож, шимтгэл, алдангийг бүрэн барагдуулсан. Мэдээллийн баазад бүртгэлтэй ажил олгогчийн 20 хүртэл хувийг шалгахаар сумдад удирдамж, чиглэлийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлэн, заавар зөвлөгөө өгч, Төсөвт байгууллагын 2024 оны баримтыг шалгахаар хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. | |
| 3.1.2. | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг шалгасан байна. | Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн удирдамжын дагуу зохион байгуулах. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | Их, дээд болон коллежийн, түүнчлэн ерөнхий боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагын шалгалтад жагсаалтаар ирүүлсэн 3 ажил олгогчийн 1 нь төсвийн байгууллага, 2 нь жолооны курс ажиллуулдаг сургалтын төв тул хяналт шалгалтын ажил зохион байгуулаагүй болно. | 100% |
| 3.1.3. | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах; | - | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, | Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн удирдамжын | Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагуудыг шалгасан байна. | дагуу зохион байгуулах. | тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна. | байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг 12 дугаар сард эхлүүлсэн бөгөөд хяналт шалгалтыг 12 дугаар сарын 20-ний дотор хийж дуусган, тайлан мэдээг хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | |
| 3.1.4. | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын Ерөнхий газраас ирүүлсэн удирдамжын дагуу шалгалтад хамрагдан, илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах | Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна. | Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 18-25-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар 127 даатгуулагчид илүү олгосон 70.4 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сая төгрөг, 24 даатгуулагчид дутуу олгосон 9.6 сая төгрөгийн төлбөр зөрчил илэрсэн.<br>Нийт 80.0 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 27.7 сая төгрөгийг барагдуулан 52.3 сая төгрөгийг барагдуулах ажлыг зохион байгуулан, даатгуулагчийн харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоон ажиллаж байна. | |
| 3.1.5. | Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх; | Батлагдсан төсвийн хүрээнд | Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах,<br>-Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна. | 2024 онд Нийгмийн хамгааллын улсын байцаагчгүй байсан тул хяналт шалгалт ажил зохион байгуулаагүй. | Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Нийгмийн хамгааллын улсын байцаагчийн орон тоо дутуу байсан тул нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй, тайлан мэдээ хүргүүлээгүй болно. | 100% |
| 3.1.6. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь,<br>НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо, | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар 177.5 сая төгрөгийн төлбөр, зөрчил | Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион | Дээд шатны байгууллагаас илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын тайлангаар оны эхний үлдэгдэл 89.9 сая төгрөг, шалгалтаар илрүүлсэн 80.0 сая | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | илэрэн 60.5 хувь буюу 107.4 сая төгрөгийг барагдуулан 70.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан, шалгалтаар илэрсэн зөрчлийн барагдуулалтын мэдээ, тайланг НДЕГ-н ХШГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна. | төгрөг, нийт 169.9 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 65.1 сая төгрөг буюу 38.3 хувийг барагдуулан ажилласан байна. Дээрх барагдаагүй нийт 104.8 сая төгрөгийн төлбөр зөрчилд ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой 87 хүний 52.8 сая төгрөг 50.4 хувийг, 2 тэтгэвэр авагчтай холбоотой 42.7 сая төгрөг 40.7 хувийг эзэлж байна. Дээд шатны байгууллагаас илэрсэн төлбөр зөрчилд эзэн холбогдогч нь нас барсан удаашралттай авлагыг бүрэн барагдуулахаар даатгуулагчийн харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоон, мөн цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Хяналт шалгалтын тайланг улирал бүр гарган хугацаанд нь хүргүүлж, мэдээ, шалгалтын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. | |
| 3.1.7. | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | - | Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах, | Дотоодын хяналт, шалгалтын тайлангаар 115.2 сая төгрөгийн төлбөр, зөрчлөөс 73.8 сая төгрөгийг барагдуулан 41.4 сая төгрөгийг барагдуулах ажлыг зохион байгуулж, тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гарган НДЕГ-н ХШГ-т хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн хагас, бүтэн жилийн тайланг үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Дотоодын хяналт шалгалтын тайлангаар оны эхний үлдэгдэл 41.5 сая төгрөг байсан. Шалгалтаар илрүүлсэн 229.6 сая төгрөг, нийт 271.1 сая төгрөгийн төлбөр зөрчлөөс 213.2 сая төгрөг буюу 78.6 хувийг барагдуулан ажилласан байна. Дотоодын хяналт шалгалтаар илэрсэн эзэн холбогдогч нь нас барсан удаашралттай авлагыг бүрэн барагдуулахаар даатгуулагчийн харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоон, мөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Тайланг хагас, бүтэн жилээр гарган хяналт шалгалтын газарт хугацаанд нь хүргүүлэн ажилласан. | |
| ***Биелэлт – 680 /7 97.1 %*** | | | | | | | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | |
| ***Зорилт 4:*** *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | | - 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна.<br>-Арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн | 2024 оны жилийн эцсийн байдлаар аймаг, нийслэлийн нийгмийн даатгалын хэлтсүүдээс НДЕГ-аас өгсөн үүрэг даалгавар, тогтоол шийдвэр, чиглэл зөвлөмж, үйл ажиллагааны тайлан, зорилтот жилийн төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн авч дүгнэхэд нийт салбарын хэмжээнд хэрэгжилт 83,5%-тай хэрэгжсэн байна. | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан мэдээтэй тухай бүр танилцаж Нийгмийн даатгалын газрын нэгжийн чиг үүрэгтэй холбоотой 81 мэдээ, тайланг цаг хугацаанд нь дээд шатны байгууллагат хүргүүлж ажилласан байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2. | Байгууллага, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | | -Улирал бүрийн 20-ны өдрийн дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлнэ.<br>-Өргөдөл шийдвэрлэлтийг 100% хугацаанд нь, үнэн зөв, бодит үр дүнтэй шийдвэрлэсэн байна. | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэлт 2024 онд 89,1 %-тай хэрэгжсэн байна. | Иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, мэдээг үнэн бодит гаргаж улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт хүргүүлнэ. | 2025 онд ажил олгогч, иргэн даатгуулагчаас 123 өргөдөл, гомдол ирснээс 118 өргөдөл гомдлыг шийдвэрлэн хариу хүргүүлэн ажилласан байна. | 100% |
| 4.3. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх; | | Төрийн албаны тухай хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг гаргасан байна. | Хууль тогтоомжийн хүрээнд хүний нөөцийг бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах. | Орон тоо, төсвийн хүрээнд хүний нөөцийг томилох, чөлөөлөх шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргаж НДЕГ-т Тамгын газарт улирал бүр тайлагнах. | НДЕГазрын даргын 2025 оны 9 дүгээр сарын 10-ний өдрийн А/239 дугаар тушаалаар 41 орон тоо батлагдсан.<br>Үүнээс 37 ажилтан албан хаагч ажиллаж, хүүхдээ асрах чөлөөтэй 1, жирэмсний болон амаржсаны чөлөөтэй 1 байцаагч байна. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан орон тооны дээд хязгаарыг хэтрүүлэлгүй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн 6 албан хаагч, түр орлон гүйцэтгэгч 1 албан хаагчийг тус тус томилсон. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоо /2 удаа/ гарсныг тухай бүр аймгийн салбар зөвлөлд хүргүүлэн ажилласан. Газрын албан ёсны facebook хуудас болон Хэнтий аймгийн ЗДТГ-ын албан ёсны цахим хуудсанд сул орон тооны зарыг нийтэд тогтмол мэдээлэн ажиллаж байна. | |
| 4.4. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх; | | Холбогдох судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлсэн байна. | Нийгмийн даатгалын байгууллагад тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллаж 2 ба түүнээс дээш удаа улсын байцаагчийн эрхээ баталгаажуулсан 8 байцаагчийн материалыг хүргүүлж, нэмэгдлийг | Судалгааг үнэн зөв гаргаж холбогдох баримтыг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зэрэг дэв олгох, ахиулах боломж шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээ судалгааг гарган, албан хаагчдын хувийн хэргийг шинэчилж гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан. Төрийн албаны | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | зохих ёсоор олгосон. | | тухай хуулийн хүрээнд 2 байцаагч шинээр зэрэг дэвийн нэмэгдэл олгох, 4 байцаагчийн зэрэг дэвийг ахиулахаар холбогдох материалыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, захирамж гаргуулан нэмэгдлийг зохих ёсоор тооцон олгож байна. Мэргэжлийн “Зөвлөх” зэрэгтэй 2, “Итгэмжит” зөвлөх зэрэгтэй 5 байцаагчид тус тус НДЕГ-с ирсэн тушаалын дагуу нэмэгдлийг олгож байна. | |
| 4.5. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас батлагдсан “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | | Хэрэгжилтийг 2025 оны 06 дугаар сарын 10, 12 дугаар сарын 10-ны дотор Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн байна. | Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлнэ. | Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, үр дүнг 06 сарын 20, 12 сарын 20-ны дотор НДЕГ-ын Тамгын газарт тайлагнасан байна. | Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд тус газар нь байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж байцаагч ажилтнуудын нийгмийн баталгааг хангах тусламж, дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулал олгох зүйл заалтыг сайжруулан баталсан. Мөн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Төрийн албаны тухай хуулийн хүрээнд зэрэг дэв олгох, ахиулах шаардлага хангасан төрийн албан хаагчдын мэдээ судалгааг гарган холбогдох газарт хүргүүлэн, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 4.6. | Албан хаагчдын ХАСХОМ гаргах ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх; | | Авлигын тухай хуулийн дагуу хугацаанд хүргүүлсэн байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулах. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаан даа мөрдөж ажиллана | НДЕГазраас ирүүлсэн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны Мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажил хангаж ажиллах тухай 01/02 тоотын хавсралт, Авлигатай тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны 05/21246 тоот, 2025 оны Мэдүүлгийн бүрдүүлэлтийн бэлтгэл ажлыг хангах тухай чиглэлийн дагуу мэдүүлэг гаргах үүрэгтэй албан тушаалтнуудад 2024 оны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргах талаар мэдээлэл өгч, ХАСХОМ-ын маягт бөглөх зааврыг бичлэгээр дотоод сүлжээнд байршуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтыг Авлигатай тэмцэх газрын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 05/21246 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтаар гарган баталгаажуулж дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн. Мэдүүлэг гаргах 17 албан тушаалтны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд шинэчлэн мэдүүлж тайланг НДЕГазарт хүргүүлэн ажилласан. | |
| 4.7. | 2025 онд гарсан хууль эрх зүйн зөрчил, шүүхээр шийдвэрлүүлсэн маргаан, хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны судалгааг хүргүүлэх; | | - Судалгааг тухай бүр нь хүргүүлсэн байна. | - | Судалгааг үнэн зөв гаргаж, холбогдох баримт, мэдээллийг Захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтэст хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын газар нь 2025 онд НДШ-ийн өртэй 7 ажил олгогчтой холбоотой нэхэмжлэлийг Хэнтий аймгийн сум дундын шүүхэд шилжүүлэн ажилласан. Мөн тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголттой холбоотой 2 даатгуулагчийн гомдол | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн дагуу шүүхийн үйл ажиллагаанд хариуцагчаар татагдан оролцсон байна. | |
| 4.8. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр нь хүргүүлж ажиллах; | | -Хугацаанд нь хүргүүлэх,<br>-Баримтын чанар, үзүүлэлт тодорхой байна. | Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь ирүүлсэн байдал 85%-тай байв. | Үүрэг даалгавар, албан бичиг, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн Засаг даргын тамгын газар болон хамтран ажиллагч байгууллагуудаас 463 хугацаатай албан бичиг, үүрэг даалгавар, чиглэл ирсний 460 ирсэн бичигт хариу хүргүүлж ажилласан байна. Баримт бичгийн хариуг холбогдох хууль тогтоомж, зөв бичих дүрэм, стандартад заасан шаардлагын дагуу зохион бүрдүүлж, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг ханган боловсруулж, хянуулан баримтжуулж холбогдох байгууллагад шуурхай илгээн ажилласан. | 100% |

***Зорилт 4.1:** “Нийгмийн даатгалын байгууллагыг мэргэшсэн хүний нөөцөөр бүрдүүлэх, байцаагч, ажилтныг чадавхжуулах, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургалтыг системтэй, мэргэжлийн түвшинд байнга тасралтгүй явуулах, нөгөө талаар ажил олгогч, даатгуулагчдад нийгмийн даатгалын талаарх хууль эрх зүйн мэдлэг олгох хичээл сургалтыг нэгдсэн хөтөлбөрийн дагуу зохион байгуулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:***

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг зохион байгуулах; | | -Авлигаас урьдчилан сэргийлэх 2 удаагийн сургалт зохион байгуулах,<br>-Нийт албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 5 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | Газрын албан хаагчид авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг дээшилж, үйл ажиллагаан даа мөрдөж ажиллана. | Газрын ажилтнуудад авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа зохион байгуулж НДЕГазар болон АЗДТГазраас зохион байгуулж байгаа "Нэг цаг, нэмэх цэнэг" сургалтад цахимаар 5 удаа хамрагдаж нийт давхардсан тоогоор 116 албан хаагч хамрагдсан.<br>2025.05.08-нд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, орон нутагт ажиллаж амьдрах эрхийн баталгааг хангахад анхаарах асуудлыг тодорхойлох” сэдэвт сургалтад 23 байцаагч хамрагдсан.<br>2025.05.15-нд “Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн албан хаагчийн ёс зүйн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөрчлөөс урьдчилан сэргийлэх," сэдэвт сургалтад 25 байцаагч хамрагдсан.<br>2025.07.04-нд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ сэдвээр НДЕГ-ын ёс зүйн дэд хорооноос сургалт зохион байгуулсан 31 албан хаагч хамрагдсан.<br>2025-06-04 НДЕГ-с Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ сэдэвт сургалтад ёс зүйн дэд хорооны 5 гишүүд бүрэн хамрагдсан.<br>2025-11-17-нд НДЕГ-аас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Авлигын эсрэг хууль", "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн сургалтад 32 албан хаагчийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахимаар хамруулсан. | |
| 4.1.2. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | - Сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>-Албан хаагчдыг 100% хамруулсан байна. | Албан хаагчдыг чадавхижуулах, ур чадварыг дээшлүүлэх 13 удаагийн сургалтад 840 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав. | Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруул ж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх цахим болон танхимын сургалтыг зохион байгуулсан байна. | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 66 төрлийн сургалтад давхардсан тоогоор 1738 албан хаагчийг хамруулсан.Үүнд:<br>Төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан тоо 8, хамрагдсан хүний тоо 208<br>Монгол бичгийн сургалт зохион байгуулсан тоо 1, хамрагдсан хүний тоо 30<br>Сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтний шинээр санаачлан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо 4, хамрагдсан хүний тоо 30,<br>Бусад сургалтын тоо 53, хамрагдсан хүний тоо 1470 | 100% |
| 4.1.3. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | -Даатгуулагчид чиглэсэн сургалтыг өмнөх оноос 10-аас доошгүй хувиар зохион байгуулах,<br>- 30-аас доошгүй аж ахуйн нэгжийг хамруулах, | Ажил олгогч, иргэд, даатгуулагчид чиглэсэн 244 удаагийн сургалтад 126 аж ахуйн нэгжийн 9906 иргэд, | Ажил олгогч, иргэд, даатгуулагч ийн нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн ойлголтыг | ААН албан байгууллага, иргэд даатгуулагчид чиглэсэн сургалтын хүрээнд 265 удаагийн сургалтаар 831 нэгжид сургалт уулзалт хийж, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -Иргэд, даатгуулагчдын 10-иас доошгүй хувийг хамруулсан байна. | даатгуулагч, ажил олгогчийг хамруулав. | дээшлүүлэх сургалт, арга хэмжээг зохион байгуулж, иргэд даатгуулагчийг өргөнөөр хамруулсан байна. | 13391 иргэд, даатгуулагчид сургалт, уулзалтад хамрагдуулан ажилласан байна. | |
| ***Зорилт 4.2:*** *"Нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх, сайжруулах, цахим, нэг цэгийн болон явуулын хэлбэрээр нийгмийн даатгалын үйлчилгээг явуулах, олон нийт, харилцагч болон харьяа байгууллагуудад мэдээлэл түгээх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.2.1. | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг ханган ажиллах; | - | Шинээр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулна. | Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний болон ажлын байрны стандартыг мөрдөж ажилласан. | Ажлын байрны болон үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах чиглэлээр улирал бүр 1-ээс доошгүй шинэлэг арга хэмжээ санаачлан зохион байгуулж, үр дүнд хүрсэн байна. | Аймгийн засаг даргатай хамтран ажиллаж ажил олгогч, албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулан сургалт сурталчилгаа, үйл ажиллагаа зохион байгуулах 9355000 (есөн сая гурван зуун тавин таван мянган) төгрөгийн хөрөнгийг засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргуулан сумдад ажиллах, сургалт сурталчилгаа хийх нарийвчилсан төлөвлөгөө гарган амжилттай зохион байгуулан ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.2. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах; | - | Дуудлага алдалт 10%-аас хэтрүүлэхгүй ажилласан байна | Ирсэн дуудлага 2502, дуудлага алдалт дунджаар 42 %. | Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч, ажилласан байна. | Жилийн эцсийн байдлаар нийт 13480 дуудлага ирснээр 10918 дуудлагад хариу өгч 81 хувьтай дуудлагыг хүлээн авч иргэд даатгуулагчдад түргэн шуурхай мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна. Дуудлага алдалт 2561 буюу 19 хувийг нь алдсан байна. | 85% |
| 4.2.3. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах, хэвлэл мэдээллийн байгууллагыг мэдээллээр хангах; | - | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааг<br>- “Рийл” улиралд 3-аас доошгүй удаа;<br>- “Постер” сард 3-аас доошгүй удаа;<br>- “Видео контент” улиралд 1 удаа;<br>- Хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан мэдээ мэдээлэл өгөх, сард 2-оос доошгүй удаа; | Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр сурталчилгаа хийсэн 130 тоо, мэдээллийн төрөл 5 | Нийгмийн даатгалын багц хууль, хуулийн ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. ГБХНХЯ болон НДЕГ- | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ажил үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ, цахим хуудсаар болон бусад хэлбэрээр иргэд даатгуулагчид шуурхай хүргэн ажилласан байна. 2025 онд Нийгмийн даатгалын газар нь “Хэнтийн Мэдээ сонин” агентлагтай хамтран ажиллах гэрээ байгуулан Нийгмийн даатгалын хуулийг сурталчлах, нийгмийн даатгалын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | аас бэлтгэсэн мэдээллийг бүх албан хаагчдаар цааш түгээлгэж, олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулсан байна. | байгууллагын үйл ажиллагааг иргэд даатгуулагчид түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулан ажилласан. Гэрээний хүрээнд 14 reel, content, 12 постерийг хийж олон нийтэд түгээсэн байна. Мөн НДЕГ болон Хэнтий аймгийн НДГ-ын пост, reel, мэдээ, мэдээллийг тухай бүр иргэд даатгуулагчид хүргэх, түгээх ажлыг нийт албан хаагчид хамтран шэйрлэж, түгээж хэвшсэн. Дээрх хийгдсэн ажлыг 2025 онд нийт 3011 удаа постолж, шэйрлэж, түгээн давтагдсан тоогоор 840 гаруй мянган хүний хандалт авсан байна. | |
| 4.2.4. | Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авдаг иргэдийн тэтгэврийн хувийн хэрэг, материалыг цахимжуулах ажлыг зохион байгуулах | | Тэтгэвэр авагчдын хувийн хэргийг 80% цахимжуулсан байна. | - | Тэтгэвэр авагчдын хувийн хэрэг, материал бүрэн цахимжсан байна. | Нийгмийн даатгалын газрын дотоод ажлыг сайжруулах ажлын хүрээнд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын хувийн хэргийг цахимжуулах ажлыг зохион байгуулан ажиллаж 13082 тэтгэвэр авагчийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувийн хэрэг материалыг PDF, GPG өргөтгөлөөр 100 хуулбарлан цахим сан үүсгэн бэлтгээд байна. НДЕГ-аас цахим хувийн хэргийн программ худалдан авах нөхцөл боломжоор хангасан тул тухайн программыг худалдан авч тэтгэврийн хувийн хэрэг материалыг цахим программд байршуулах ажил зохион байгуулагдаж байна. | |
| ***Зорилт 4.3:*** *"Нийгмийн даатгалын харилцаанд оролцогч талуудад эрүүл мэндийн магадлалын чиглэлээр мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх"* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | |
| 4.3.1. | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагааны чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр ижил мэргэжилтний үзлэг зохион байгуулж, цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд тавих дотоодын хяналтыг эрчимжүүлж ажилласан байх | | Ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, удирдамж, тайлан | 2024 онд 1 удаа зохион байгуулсан байна. 2024 онд 1-4 удаа зохион байгуулсан. | Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад ижил мэргэжилтний үзлэгийг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээ авсан байна. | ЭММЗөвлөл нь тайлант хугацаанд 42 удаа хуралдаж 1556 иргэний асуудлыг хянан шийдвэрлэсэн ба ЭММЗөвлөлийн хурлын ирц 70-90 хувьтай хуралдсан байна. Зөвлөлийн хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа шалтгааныг шийдвэрлүүлж буй иргэдийн оношийн баталгаажилтад дотоодын хяналтыг хийж ажил | 95% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Дотоод хяналтын төлөвлөгөө, тайлан | | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдүүлэлтэд сар бүр хяналт тавьж, цахим мэдээллийн сангийн бүртгэлийг нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулган шалгах ажлыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж, зөрчлийг арилгаж ажилласан байна. | мэргэжилтний үзлэгийг гэмтэл, дотор, мэдрэлийн чиглэлээр 3 удаа мөн төв комисоос 2 удаа, Дорнод аймгийн ЭММЗөвлөлтэй хамтран тус тус зохион байгуулсан бөгөөд ижил мэргэжилтний үзлэгээр гарсан алдаа зөрчлийг холбогдох эмч нартай уулзаж зөвлөгөө өгч 2 иргэнийг цуцлаж 3 иргэнийг нарийн мэргэжлийн эмчид үзүүлж дахин шинжилгээнд хамруулахыг зөвлөж ажилласан. Цахим мэдээллийн сангийн бүртгэлийг 4 дүгээр сард нийгмийн даатгал болон нийгмийн халамжийн байгууллагаас тэтгэвэр авагчдын бүртгэлтэй тулгалт хийн шалгасан ямар нэгэн зөрчил илрээгүй. Мөн мэдээллийн баазад сар бүр хяналт тавьж даатгуулагчийн, овог нэр, хаягийн бүртгэлийг тулган шалгасан 1 зөрчил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гарсныг сумын байцаагчтай холбогдон залруулж, шилжилт хөдөлгөөн хийгдээгүй 2 иргэнийг Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянзүрх дүүрэг, 2 хоригдлыг Сүхбаатар, Дорнод аймагруу шилжүүлсэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадалсан шийдвэрийн хуудасны бичилтэд хурал болгоны дараа хяналт тавьж зөрчлийг дор бүр арилган ажилласан. | |
| 4.3.2. | Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах, эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх. | | Хийсэн судалгаа, дүн шинжилгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх бууруулах чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөө, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн цахим мэдээллийн сангийн бүрдэлд хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын нарийн бичгийн дарга, | Аймаг, дүүргийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн судалгаанд үндэслэн дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, | Аймаг, сумын хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдлыг 2025 оны хагас жилийн тайланд үндэслэн нэгдсэн судалгааг өвчлөл төрөл бүрээр, /насжилт/-аар нь гаргаж дүн шинжилгээ хийж ажиллаа. Манай аймгийн нийт хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо 2786 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | гишүүдийн бүрэлдэхүүнтэй гээр мэдээллийн цахим санг хувийн хэрэгтэй тулган шалгах хяналт, шалгалтыг ажлыг 2 удаа зохион байгуулсан. | сэргийлэх чиглэ-лээр холбогдох байгууллагатай хамтран тодорхой арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | буюу 2,9 хувьтай улсын дунджаас 0.4 хувиар өндөр байна. Судалгаагаар Мөрөн, Баян-Адрага, Баянмөнх, Хэрлэн, Баян-Овоо, Бэрх, Батширээт, Биндэр, Дадал, Бэрх сумдын хөдөлмөрийн чадвар алдсан иргэдийн тоо улсын дунджаас өндөр 2.9-4,6 хувьтай байгаа тул эдгээр сумдын нийт 1038 иргэн буюу 81 хувьд дахин магадлал хийж тухайн суманд очиж хурлын бүрэн бүрэлдэхүүнтэй ажилласан. Дахин магадлалаас нийт 14 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцалж, 254 хүнийг нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээнд хамруулах, 125 иргэнийг хэвтэн эмчлүүлэх, нэн яаралтай 8 өвчтөнийг 3 дахь шатлалын эмнэлэгт эмчлүүлэх, 302 иргэнд зөвлөгөө өгч, 10 иргэнийг | |
| | | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн хадгалалт, эмх цэгцийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан | | Иргэний эрүүл мэндийн анхан шатны баримт бичиг /амбулаторийн карт, рентгент зураг, CD8 DVD зэрэг/-ийн эмх цэгц, хадгалалт хамгаалалтыг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллаж, үр дүнд хүрсэн байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | асаргаанд оруулах асуудлыг шийдвэрлэсэн. Сумын эрүүл мэндийн төвийн эмч нарт хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн эрүүл мэндийн хяналт эмчилгээний үр дүн хяналт, ар гэрийн асаргаа хараа хяналтад зөвлөгөө хүргэх улирал тутмын хяналтыг сайжруулах, иргэддээ хүрч үйлчлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллах талаар зөвлөгөө зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан. Эрүүл мэндийн анхан шатны баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах чиглэлээр холбогдох ЭММЗөвлөлийн гишүүд болон сум, өрхийн эмчлэгч эмч нарт зөвлөгөө өгч Амбулаторийн карт хувийн хэргийн хөтлөлт, хавтаслалт эмх цэгцийг байнга хянан шалгаж харъяа газруудтай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөлдөн хамтран ажиллаж байна. | |
| 4.3.3. | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | | Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан | 2024 онд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан | Эрүүл мэндийн магадлал болон эмнэлгийн хуудас бичилт олголттой холбоотой хууль тогтоомж, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүдэд 2-оос доошгүй удаагийн сургалт зохион байгуулсан байна. | “Даатгуулагч, иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлах өвчний жагсаалт батлах тухай”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”-ын талаарх сургалтыг тэтгэмжийн байцаагч Б.Алтансувдтай хамтран 2025 оны 02 дугаар сарын 5-14-ны өдрүүдэд танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Сургалтад нийт 70 эмч ажилчид хамрагдсан. ЭММТЗөвлөлөөс, АТГазрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэстэй хамтран Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авлигын гэмт хэргийн талаарх ээлжит сургалтад 2025-05-28-нд цахимаар оролцож 5 эмч, 3 мэргэжилтэн хамруулсан. 2025 оны 05 дугаар сард Магадлагч эмч нарын зөвлөгөөнд хамрагдаж Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад 3 эмч, мэргэжилтэн хамрагдсан. “Харааны бэрхшээлтэй даатгуулагч хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадлах, хөдөлмөр зохицуулалт хийхэд баримтлахад анхаарах нь” сургалтад оролцож сургалтан дээр АТГазраас авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад сууж ирээд хурлын 6 гишүүнд мэдээлэл хүргэж ажилласан. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сургалт, өдөрлөг, цахим сурталчилгааны тоо, мэдээлэл авсан иргэдийн тоо, тайлан | 2024 онд 3-аас доошгүй удаагийн сургалт, нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж мэдээлэл өгсөн | Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдтэй хамтран эрүүл мэндийн магадлалын талаар ерөнхий мэдээлэл өгч, иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох сургалт, сурталчилгаа хийж мэдээллээр хангасан байна. | Сумдын ХБИргэдийн холбоотой хамтран ажиллаж холбогдох мэдээ тайлан, зөвлөгөө зөвлөмж, ХЧАлдалтыг бууруулах, эмчлэн эрүүлжүүлэх, хөдөлмөрийн чадварыг нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар 4 удаагийн сургалтаар 565 иргэдэд мэдээлэл өгч ажилласан. 2025 оны 1 дүгээр сарын 23-ний өдөр Баянхутаг сумын иргэдэд “Эмнэлгийн хуудас олгох бичих журам, иргэдийн үүрэг оролцоо” сэдвээр төрийн болон төрийн бус байгууллага иргэдэд сургалт зөвлөгөө өгч ажиллалаа. Сумын 3 эмч эмнэлгийн 4 мэргэжилтэн, иргэд гээд нийт 115 иргэд оролцлоо. 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр Хэрлэн сумын соёлын төвд ХБИргэдийн уулзалт өдөрлөгт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оролцож Хэрлэн сумын өрхийн 3 эмч тусгай мэргэжилтэн 2 болон 125 иргэдэд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн мэдээлэл” сэдвээр сургалтыг хийж мөн 2024 оны Эрүүл мэндийн магадлалын тайланг танилцуулж, зөвлөгөө зөвлөмжүүдийг өгч ажилласан. Мөн 05 дугаар сард “Нийгэмд оролцоотой байя” хөгжлийн бэрхшээлтэй иргэний чуулганд оролцож 200 гаран иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа. 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах өдөр ХХҮГазартай хамтран өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр ЭММЗөвлөлийн үйл ажилгааг танилцуулан, мэдээлэл өгсөн. 2025 онд нийтдээ 11 удаагийн цахим | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтыг зохион байгуулсан байна. | |
| 4.3.4. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулах | | Хэрэгжүүлсэн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн тоо | 2024 онд 5 үүрэг даалгаврын биелэлтийг хангаж, эрүүл мэндийн магадлалын чиглэлээр 4 судалгаа хийж тайланг Төв зөвлөлд хүргүүлэн ажилласан | Дээд газраас өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтий г хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | Эрүүл мэндийн төв зөвлөлөөс өгсөн чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хэрэгжилтийг дор бүр нь эрүүл мэндийн гишүүдэд танилцуулж чиглэлийн дагуу үүрэг даалгавар өгч ажиллаж байна. 2025 оноос эхлэн ЭММЗ-ийн цахим хуудсыг ажиллуулж тогтмол мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэн ажиллаж байна. Аймгийн нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг сум тус бүрээр гаргаж цахим хуудсууд болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлж байна. | 100% |
| *Зорилт 4.4: “Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 4.4.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх; | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг | 2024 оны 01 дүгээр сараас ашиглалтад орсон Нийгмийн даатгалын шинэ систем нь Улсын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүрэн бүрдүүлсэн байна. | бүртгэлийн мэдээллийн сангаас даатгуулагчийн мэдээллийг шууд татдаг болсон тул даатгуулагчийн мэдээлэл зөрөх, буруу тохиолдолд хүлээн авах боломжгүй програмчлагдсан тул алдаа зөрчил гарахгүй болсон. | |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх<br>Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | | - Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 4.4.2. | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх; | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Албан журмын болон сайн дурын даатгалыг | Тайлант хугацаанд мэдээлэл засварлах шаардлагатай 4257 ажил | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | давхардуулан бүртгэхгүй байх | | нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | олгогчийг хамралт орлого, шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэдээлэл технологийн мэргэжилтэн, Бор-Өндөр сумын нийгмийн даатгалын тасгийн нэг цэгийн үйлчилгээний мэргэжилтэн нарт хуваарилан ажилласан. Ажил олгогчийн мэдээллийг Улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татаж, үйл ажиллагаа нь зогссон ажил олгогчийг идэвхгүй төлөвт болгох, нэг ажил олгогч дээр олон бүртгэл үүссэнийг нэгээс бусдыг нь идэвхгүй төлөвт оруулах, эдийн засгийн ангиллыг улсын бүртгэлийн гэрчилгээнд бичигдсэн үйл ажиллагааны чиглэлийн кодоор засах зэрэг ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | |
| 4.4.3. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах; | | Програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | | Програм хангамжуудын эрхийн тохиргоог зөв хийх, | 2025 онд сумдад шинээр нөөтбүүк 5, газарт 2, суурин компьютер газар , гурван үйлдэлт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байцаагч ажилтнууд програм хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. | принтер газарт 8, суманд 9, Mobicom-ийн манай интернэт төхөөрөмж суманд 13, газарт 1, сканер 2, таблет 4 ширхэг шинээр ирж, хуваарилж ажиллагаанд оруулсан. Байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагааны хэвийн байдлыг хангах хүрээнд тус газрын байранд сервер 1, router 1, шилэн кабелийн төхөөрөмж 2, конвертер 1, wifi төхөөрөмж 3, switch 8, kiosk төхөөрөмж 1, танилцуулга, мэдээлэл хүргэх, цахимаар үйлчилгээ авах дижитал дэлгэц 1, цаг бүртгэлийн төхөөрөмж 1, видёо мэдээлэл, шторк мэдээлэл хүргэх дэлгэц 1, үнэлгээний төхөөрөмж NVR 1, камер 7, Дохиолол хамгаалт, хяналтын камерын тоног төхөөрөмжүүд Үүнд: Дохиоллын станц, Мэдээ дамжуулагч, дуут дохиологч, NVR | |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | | МТТ-өөс зохион байгуулсан ажлын гүйцэтгэл, албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь үнэн зөв бүрэн ирүүлсэн байна. | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бичигч 2, свич 2, Гадна камер 7, дотор камер 10, утаа мэдрэгч 18, компьютер 27, принтер газарт 17, сумдад компьютер, принтер 21-ыг ашиглаж байна. Дээрх тоног төхөөмжүүдийн хэвийг байдлыг шалгаж эвдэрч гэмтэх, доголдол гарах бүрд шуурхай засварлаж хэвийн ажиллааг хангаж ажилласан. Үүнд: шинэ 10 компьютерт программ хангамжуудыг суулгаж, тохиргоо хийсэн. Шинэ 9 принтерийн тохиргоо холболтууд хийсэн. Шинэ 14 wifi төхөөрөмжийн тохиргоог хийсэн. 13 компьютер формат, хэрэглээний программууд болон, үйлчилгээ, үйл ажиллагааны зориулалтын программ хангамжуудыг суулгасан. Лиценз дуусан windows систем, Microsoft office программын | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сунгалт 22, Сүлжээний доголдол засварлах ажил 35, конверт гэмтэж эвдэрсэн 1 тохиолдол гарч төхөөрөмж шинээр авч хэвийн ажиллагаанд оруулсан. Принтер тохиргоо, засвар үйлчилгээг 40 удаа хийсэн. Хуучин сервер төхөөмжийн үйлдлийн систем гэмтэж хуучин программ хангамжууд ажиллахгүй болсныг “Мэдээллийн технологийн төв”-д хандаж хэвийн ажиллагаанд оруулсан. Шинэ веб программ, ажлын хэрэглээний чат, мэйл бусад программ хангамжийн хэвийн ажиллагааг өдөр тутамд шалгаж тухай бүр тохиргоо, засвар үйлчилгээг хийж ажилласан. Цаг бүртгэлийн төхөөрөмжөөс хэвийн ажиллагааг өдөр бүр хянаж бүртгэлийн мэдээллийг “Able, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ERP” программд татуулж ажиллаж байна. | |
| ***Биелэлт – 2170 / 22 98.6 %*** | | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | | |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох; | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна.<br>-Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинтэй байна | Үндэсний бичигт хөрвүүлэх | Үндэсний бичгээр баримт боловсруулах арга зүй сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 19-ны өдөр НДЕГ-с цахимаар зохион байгуулсан ба дээрх сургалтад нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан. Мөн байцаагч ажилчдын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэсний бичгийг бие даан судлах, мэдлэг чадвараа дээшлүүлэх арга хэмжээг тусган ажиллаж байна. | 2025.01.01<br>2025.12.31 | 100% |
| 2 | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах; | Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна. | Удирдах ажилтны сургалт-зөвлөгөөнд 2 удаа хамрагдсан. | Зохион байгуулагдсан хугацаанд | Нийгмийн даатгалын салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд 2025 оны 12 дугаар сарын 11-12-ний өдрүүдэд хамрагдсан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулдаг удирдах ажилтны хурал, зөвлөгөөнд тухай хамрагддаг. | 2025.01.01<br>2025.12.31 | 100% |
| 3 | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах; | Удирдлагын манлайллын ур чадварын өнөөгийн түвшингээ тодорхойлж, хувь хүний манлайлах ур чадвараа ахиулах сургалтад 1-ээс доошгүй удаа хамрагдана. | - | Тухай бүр | МУИС-ийн шинжлэх ухаан технологийн улаанбаатар парк-аас зохион байгуулсан “Манлайлал ба инновац” сэдэвтэй сургалтад 1 удаа хамрагдсан. | 2025.01.01<br>2025.12.31 | 100% |
| 4 | Компанийн засаглалын сургалтад хамрагдах; | Удирдлагын ур чадвар, эрх зүйн ойлголт, гүйцэтгэх удирдлага, хариуцлагатай ажилтан, хувь хүний талаар мэдээлэлтэй болсон байна. | - | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 78.5 дахь заалтыг үндэслэн Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга” нарын сургалтад 1 удаа хамрагдсан. | 2025.01.01<br>2025.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж мод тарина | Тарьсан модыг арчилж ургуулсан байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж нийт 138 мод тарьсан. | III улирал | Тус газар нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд байгууллагаараа нэгдэж 2025 оны 05 дугаар сарын 23-ний өдөр хуваарьт талбайд 60 ш хайлаас мод, 2025 оны 10 дугаар сарын 03-ний өдөр 20 ш улиас мод тарьж ажилласан. | 2025.01.01 2025.12.31 | 100% |
| ***Биелэлт 500 / 5 100 %*** | | | | | | | |
| ***Нийт үнэлгээ 491.5 / 5 98.3 %*** | | | | | | | |

**Төсвийн төвлөрүүлэн захирагч**

Тайланг хянасан:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ............................. /Б.БАТЖАРГАЛ/

(Албан тушаал) тэмдэг (гарын үсэг) огноо

Төлөвлөгөө тайлагнасан: **Төсвийн шууд захирагч**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА ............................. /Н.НЯМХАТАН/

(Албан тушаал) тэмдэг (гарын үсэг) огноо

Мэдээлэл лавлах албан хаагч:

| **НЭР** | **АЛБАН ТУШААЛ** | **ЦАХИМ ШУУДАН** | **УТАС** | **ӨРӨӨНИЙ №** |
|---|---|---|---|---|
| Н.Цолмонбаяр | Захиргаа хяналтын хэлтсийн дарга | tsolmonbayar.n@ndaatgal.mn | 88052416 | 202 |